

**БНМАУ-Д СУУРЬШМАЛ БОЛОН
НҮҮДЭЛЛЭН АЖ ТӨРӨХ ЁС
ОРЧИН ҮЕД ЗЭРЭГЦЭН ОРШИЖ
ХАРИЛЦАН НӨЛӨӨЛЖ БУЙ
АСУУДАЛ**

ГРАЙВОРОНСКИЙ В. В.

Түүхийн ухааны дэд эрдэмтэн (ЗСБНХУ)

Монголчууд түүхийн тавцанд анх гарч ирсэн цагаасаа эхлэн гол төлөв нүүдлийн мал аж ахуй эрхлэн, нүүдэлчин ёсоороо амьдарсаар ХХ зуунтай золгосон билээ. Орос, Зөвлөлтийн болон гадаадын олон эрдэмтдийн ажиглалт, бүтээл судалгаанаас авч үзвэл, 1921 онд ардын хувьсгал ялахын өмнө Монголын ард түмний дийлэнхи хэсэг нь хөдөө нутагт оршин сууж нүүдэлчин амьдралтай байсан билээ. Ийм учраас орчин үеийн түүхийн болон угсаатны зүйн шинжлэх ухаанд биеэ даасан, тусгай этнос болох монголчуудыг нүүдэлч малчдын аж ахуй-соёлын хэв шинжийн сонгодог төлөөлөгч мөн гэж үзсээр ирсэн нь санамсаргүй зүйл бишээ.

Гэтэл ардын хувьсгал ялан мандсанаас хойш өнгөрсөн 66 жилд Монголын ард түмний амьдралын бүхий л хүрээнд үүний урьд олон зуун жилийн дотор үзэгдээгүй тийм асар их үндсэн өөрчлөлт гарсан байна.

1921 оны ардын хувьсгалын дараахь Монгол улсын улс төр, нийгэм—Эдийн засгийн хөгжлийн хамгийн гол онцлог нь дундад зууны үеийн феодализмаас капитализмыг алгасч социализмд шилжин орсон явдал мөн гэж өнөөгийн дийлэнхи Монголч эрдэмтэд бараг санал нэгтэй үзэж байгаа юм. Монгол-Зөвлөлтийн эрдэмтдийн нягт, үр бүтээлт хамтын ажиллагаа, тэдний тодорхой зорилготой хүчин чармайлтын үрээр БНМАУ-ын капиталист биш хөгжлийн түүхэн туршлагын олон талыг нилээд нухацтай судлаж, олон тооны хамтын болон биеэ даасан нэгэн сэдэвт зохиолууд, эрдэм шинжилгээний өгүүллэг нийтлэгдсэн байна. Энэ нь капиталист биш хөгжлийн тухай марксист-ленинист онол, Монгол улсын шинэхэн түүх, орчин үеийн хөгжлийн судалгаа Монгол судлалыг хөгжүүлэх хэрэгт оруулж байгаа үнэ цэнэтэй хувь нэмэр юм.

Гэтэл бидний үзэж байгаагаар тус орны хувьсгалын дараахь хөгжлийн зарим чухал онцлог тухайлбал Монголын ард түмний амьдралын уламжлалт ёсонд гарсан гүн гүнзгий хувьсгалт өөрчлөлт, тус орны нийт хүн амын дийлэнхи нь нүүдлийн амьдралаас суурьшмал амьдралд шилжсэн шилжилт, тус орны түүхэн хөгжлийн бүх үе шатанд эдийн засаг, нийгэм, соёл оюун ухааны зэрэг Монгол нийгмийн амьдралын бүхий л салбарт нүүдлийн болон суурьшмал амьдралын хоёр ёс заншил хэрхэн яаж зэрэгцэн оршиж, харилцан үйлчилж нөлөөлж ирсэн зэрэг асуудлыг судлаж шинжилсэн зүйл одоогийн байдлаар хангалттай биш гэж санагдаж байна. Гэтэл Монгол улсын түүхэн туршлага чухам эдгээр онцлогийг судлах нь зөвхөн шинжлэх ухаан төдийгүй бас практик ач холбогдолтой юм.

Өнөөгийн нийгэм-эдийн засаг, шинжлэх ухаан техникийн дэвшлийн шууд нөлөөгөөр Монголын ард түмний амьдралын уламжлалт ёс үнд сэндээ өөрчлөгдөж буй гэсэн түүхийн гайхамшигт үйл явцыг бид бүхэн

гэрчлэн ажиглаж түүнд тодорхой нэг хэмжээгээр энэ өөрчлөлтөнд оролцож байгаа юм. Бидний үзэж байгаагаар энэхүү түүхэн үйл явц жигд амархан биш ихээхэн нарийн төвөгтэй ээдрээтэй олон сайн саар талтай юм. Өнөөгийн Монгол улс бол нүүдэлч малчдын уламжлалт соёл иргэншил нь орчин үеийн иргэншилтэй харилцан нөлөөлж, харилцан үйлчлэлцэж буй бөгөөд дэлхий дахины түүхэнд ховор тохиолдох улс орон мөн.

Монгол улсын түүхэн туршлага нь дэлхийн олон улсын эрдэмтэд, үүний дотор тус их хуралд оролцож байгаа эрдэмтдийн сонирхотыг улам их татах болж байгаа учир чухам үүнд л оршиж байгаа юм гэж санагдаж байна.

Монгол ард түмний уламжлалт амьдралын ёс гэдэг бол юуны өмнө нүүдэллэн аж төрөх ёсыг хэлж байгаа бөгөөд тэр нь Монголчууд биеэ даасан этносын хувьд XII зууны үед гарч ирээгүй байхад одоогийн Монгол орны нутагт бүрэлдэж буй болсон байна. Энэхүү амьдралын хэв маягийг тэд өөрсдийн өвөг дээдсээс өвлөн өнөө хүртэл олон зуун жил хадгалсаар ирлээ. Нүүдэлчдийн амьдралын уламжлал нь гүн гүнзгий амь бөхтэй төдийгүй монголын соёлын үндэс болж байдаг. Чухамхүү нүүдэллэн аж төрөх ёс нь Монголчуудыг өмнөд хөрш Хятадаас угсаатны зүйн хувьд ялгагдах үндсэн шинж болсон гэж цохон тэмдэглэвэл зохино.

Ардын хувьсгалын дараа Монголын ард түмний уламжлалт амьдралын ёсонд ихээхэн өөрчлөлт гарсан бөгөөд гарсаар байна. Хувьсгалын өмнөх үеийнхтэй харьцуулбал гадна талаас нь авч үзвэл төстэй боловч өнөөгийн Монголын малчдын нүүдлийн шинж чанар хэлбэр, цар хүрээнд ихээхэн өөрчлөлт гарсан юм. Энэ бол тусгай илтгэл тавих асуудал мөн. Бидний бодоход орчин үе шатанд Монгол улсын нийгэм эдийн засаг, соёлын хөгжлийн хамгийн гол үндсэн нэг онцлог юу вэ? гэвэл нэг талаас малчдын ихэнхи нь аж төрөн амьдарч буй уламжлалт нүүдлийн болон хагас нүүдлийн ёс, нөгөө талаас нь тус улсын нийт хүн амын дийлэнх хэсэг нь аж төрж буй орчин үеийн суурьшлал хоёр өвөрмөц байдлаар зэрэгцэн оршиж идэвхитэй харилцан нөлөөлж байгаад оршино гэж үзэж байна. Гэтэл орчин үеийн БНМАУ-ын нөхцөлд аж төрөх тус хоёр ёсны харилцан үйлчлэл нөлөөллийн шинж чанар, онцлогийг нарийвчлан судлах ажилд тус орны хөдөөгийн хүн амын янз бүрийн давхрааны дотор хөдөлгөөнт амьдралын ёс хэр зэрэг дэлгэрсэн тухай статистикийн нарийн тулгуур мэдээ сэлт байхгүйгээс ихээхэн саатаж байна. БНМАУ-ын СТТ аас жил болгон бэлтгэн хэвлүүлдэг статистикийн эмхтгэлд хүн амыг аж төрөх ёсоор нь ялган бүртгэхгүй байдаг нь харамсалтай юм.

Хувьсгалын өмнө дийлэнхи хүн ард нүүдэлчин байсан, одоо дийлэнхи нь суурьшмал амьдралтай болсон Монгол мэт оронд хүн ардын амьдралын хэв шинжийг нарийвчлан судлах шаардлагын үүднээс улсын тоо бүртгэлд дээрх үзүүлэлтийг тусгах нь зүй ёсны болон олон талын чухал ач холбогдолтой асуудал юм.

Суурьшмал нүүдэл, хагас нүүдэл буюу хагас суурьшсан ёсоороо аж төрж буй хүн амын янз бүрийн бүлэгт нь тэдгээрийн орон сууцны хэв шинж, хувцас хунар, хоол хүнсний бүрэлдэхүүн, хооллогийн ёс горимоос эхлэн сайн сайхан, ёс суртахууны тухай төсөөлөл хүртэл материаллаг болон соёл оюуны ухааны өөр өөр хэрэгцээ бий болж бүрэлдэн байсаар байгаа нь практик амьдралаас тодорхой харагдаж байна.

Бидний үзэж байгаагаар тус улсын хүн амын статистикийн тоо бүртгэлд нүүдэлчин, хагас нүүдэлчин хүн амын тоо хэмжээг ялган гаргавал малчдын онцлог өвөрмөц эрэлт хүсэлтийг улам нарийн тодорхой харгалзаж тэдгээрийн нийгмийн болон соёл ахуйн нөхцөлийг сайжруулах арга замыг сүвэгчлэн эрж хайх ажлыг илүү үр дүнтэй илүү тодорхой чиглэлтэй болгоход тус дөхөм болох юм гэж санагдаж байна.

Миний бие энэхүү илтгэлдээ «Социалист аж төрөх ёс», «нүүдэллэн аж төрөх ёс», «суурьшмал аж төрөх ёс» зэрэг ойлголт ухагдахууны хоорондын уялдаа харьцааны тухай сонирхолтой, маргаантай асуудлыг төдийлөн хөндөхгүй. Гэхдээ тус улсад уламжлалт нүүдлийн болон орчин үеийн суурьшмал хоёр ёс зэрэгцэн оршиж харилцан нөлөөлж байгаагийн хамгийн гол нэг хэв шинж гэвэл уг нь явц нь тус орны бүх хүн амын дотор социалист аж төрөх нэгдмэл нэг ёс бүрэлдээд цаашид хөгжиж буй нөхцөлд явагдаж байна гэсэн ерөнхий үндэслэлийг баримталж байна. Өөрөөр хэлбэл Социалист аж төрөх ёс» гэдэг нь илүү өргөн ерөнхий ойлголт бөгөөд «нүүдлийн болон суурьшмал аж төрөх ёс» гэсэн ойлголтыг дотроо багтааж агуулж байдаг юм. Гэтэл орчин үе шатанд БНМАУ-д социалист аж төрөх ёсыг тодорхойлоход тэр нь нүүдлийн болон хагас нүүдлийн хүн амын дотор өвөрмөц онцлогтой болж бүрэлдэж байна гэдгийг цаг ямагт анхаарвал зохино.

Өнгөрсөн 66 жилд Монголын ард түмний дотор нүүдлийн болон суурьшмал амьдралын хоорондын холбоо харилцан үйлчилгээний үндсэн хандлага, шинж чанар тодорхой болсон юм. Тус орон капиталист бус хөгжлийн замаар хөгжиж эдийн засаг нь улам нарийн олон салбартай болж үндэсний аж үйлдвэр, орчин үеийн тээвэр, харилцаа холбоо, газар тариалан, орчин үеийн боловсрол, эрүүлийг хамгаалах систем, шинжлэх ухаан, соёлын хөгжихийн хирээр урьд дан нүүдлийн амьдралтай байсан хүн амын ихээхэн хэсэг нь суурьшмал шинэ амьдралд улам их хэмжээгээр шилжиж ирсэн бөгөөд шилжсээр байна.

Нийт хүн амын тоонд нүүдлийн амьдралтай хүмүүсийн эзлэх хувь хэмжээ улам бүр багассаар байна. Монголын малчдын уламжлалт нүүдлийн болон хагас нүүдлийн амьдралын ёсонд ихээхэн өөрчлөлт гарсан бөгөөд гарсаар байна.

Хэрэв хувьсгал ялахын өмнөхөн хүн амын 90 гаруй хувь нь нүүдлийн мал аж ахуй эрхлэн нүүдэллэн амьдарч байсан хагас зуун жилийн дараа буюу 1970-аад оны эцсээр тус орны хүн амын дийлэнх олонхи нь суурьшмал амьдралд шилжсэн байна. Энэ талаар хот, хөдөөгийн хүн амын хоорондын харьцаа, суурьшилтын явцын тухай статистикийн материал бэлхэнээ харуулж байна. Зөвхөн сүүлийн 30 жилд (1956—1986) хотын хүн ам 183 мянгаас 991,8 мянгад (2, с. 82) хүрч 5,4 дахин нэмэгдсэн байхад хөдөөгийн хүн ам мөн хугацаанд 662,5 мянгаас 922,9 мянга болон нэмэгдэж 39,3 хувиар өссөн байна. (2, мөн тэнд)

1979 оны хүн амын тооллогын дүнгээр үзвэл тус орны нийт хүн амын тэн хагасаас илүү хувь (51,2%) нь хот болон хот маягийн сууринд суудаг болжээ. (3, с. 13) Ийнхүү Монголын ард түмний амьдралын уламжлалт арга ёсны түүхэнд тэмдэглэлт томоохон нэг үйл явдал гарч тус орны хотын хүн амын тоо хөдөөгийнхөөс олон зуун жилийн түүхэнд анх удаа давсан билээ. Түүнээс гадна, хөдөөгийн багахан сууринд оршин сууж буй хүн амын тоо бас л нэмэгдсээр байна. Сүүлийн 10 жилд хүн амын хотжилтын хурдац мэдэгдэхүйц буурсан боловч дээрх хандлага үндсэндээ хэвээр хадгалагдаж ирсэн байна.

1979 оны хүн амын тооллогын нийтлэгдсэн материал хөдөөгийн хүн амын оршин сууж буй бригад, суурь зэрэг үндсэн хэв шинжээр ялган анх удаа гаргасан байна. Энэ нь нүүдэллэн амьдарч буй хүний тоог баримжаалах боломжийг бидэнд олгож байна. Ийм тооцоог гаргахдаа юуны өмнө мал аж ахуйн суурьт оршин суудаг бөгөөд нүүдэллэн болон хагас нүүдэллэн амьдарч буй хүн амын тоог үндэс болгон гаргавал зохино гэж санагдаж байна.

1979 оны байдлаар мал аж ахуйн суурьт ажиллан амьдарч байсан 317,9 мянган хүн дээр бригадын төвд оршин сууж байсан 51,7 мянган хүнийг нэмж тооцвол 1979 онд нийт хүн амын 20 орчим буюу хөдөөгийн хүн амын тал хувийг эзлэх 350—360 мянган хүн нүүдэл, хагас нүүдлийн байдалтай сууж байсан гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл 1970-аад оны сүүлч 1980-аад оны эхээр тус орны 5 хүн тутмын нэг нь нүүдлийн буюу хагас нүүдлийн амьдралтай байна.

Сүүлийн жилүүдэд тус орны нүүдэлчин, хагас нүүдэлчин хүн амын тоо эрс их өөрчлөгдөөгүй юм гэж үзэх үндэстэй юм. Нөгөө талаар тус орны уламжлалт салбар болсон мал аж ахуйд ажиллах хүчин дутагдсаар байгааг үндэслэн өнөөгийн БНМАУ-д нүүдэлчдийн суурьших явц нь тус орны бодит бололцоо, хэрэгцээнээс арай нэг түрүүлж хөгжиж байна гэж дүгнэж болох юм. Энэ нь монголын ард түмний аж төрөх уламжлалт ёсны өөрчлөлтийн өнөөгийн явцтай холбогдсон бодит өвөр мөн зөрчлийн нэг болно. Энэхүү зөрчлийн үндэс юу гэвэл нэг талаас тус орны эдийн засгийн чухал салбар болох мал аж ахуйг уламжлалт арга орчин үеийн шинжлэх ухаан техникийн ололтыг хослуулан хамгаалах, цаашид хөгжүүлэн шинэчлэх шаардлага, нөгөө талаас малчдын хөдөлмөр ахуйн нөхцөлийг сайжруулах, тэдний улам бүр өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээ хоёр болно. Хот, хөдөөгийн суурьшмал болон нүүдэлчин хүн амын хөдөлмөр ахуйн нөхцөл өнөө хирнээ ихээхэн ялгаатай учир үлэмж тооны залуучууд уламжлалт мал аж ахуйн салбарыг орхиж хөдөөнөөс хотод шилжих үйл явцын гол нэг хүчин зүйл болсоор байна.

Хөдөөгийнхтэй харьцуулан үзвэл хот, хот маягийн сууринд орчин үеийн суурьшмал амьдрал, тохилог байр, тогтмол цагтай ажлын өдөр, ерөнхий боловсрол болон техник мэргэжил, соёл, боловсролын түвшингээ дээшлүүлэх илүү өргөн бололцоотой байдаг нь хөдөөгийн залуучууд хот руу тэмүүлэн суурьших явдлыг ихэсгэж байгаа нь маргаангүй юм. Бүрэн ба бүрэн бус дунд боловсрол эзэмшсэн өнөө үеийн хөдөөгийн залуусын материаллаг болон оюун санааны эрэлт хэрэгцээ нь тэдгээрийн ахмад үеийн малчид-эцэг, эхийн хэрэгцээнээс нилээд өөр болж бүрэлдэж буй нь тодорхой юм.

Ер нь залуучууд хөдөөнөөс хот руу тэмүүлэх, хүн амын хотжилт зөвхөн Монголд төдийгүй, нийгэм-эдийн засгийн байгууламжийг харгалзахгүйгээр бусад олон оронд нэгэн адил өргөн дэлгэрсэн байна. Гэхдээ БНМАУ-ын нөхцөлд энэхүү үйл явц нь өвөрмөц шинж чанартай болж байна. Ийм учраас МАХН, Засгийн газраас сүүлийн жилүүдэд малчдын хөдөлмөр ахуйн нөхцөлийг сайжруулах талаар ихээхэн анхаарч олон талт арга хэмжээ авсаар байна. Үүнд 1987 оны 12-р сард болсон МАХН-ын Төв Хорооны IV бүгд хурлын шийдвэр тогтоол онц чухал ач холбогдолтой юм. Одоо хөдөө аж ахуйн нэгдлийн хөдөлмөр зохион байгуулалт, хөлс төлөлтийг боловсронгуй болгох, малчдын, хөдөлмөр

ахуйн нөхцөлийг сайжруулах талаар хэд хэдэн чухал тогтоол, шийдвэр гаргаад хэрэгжүүлж байна.

Нүүдэлчдээс суурин, хагас суурин, хагас нүүдэлчин амьдралд шилжих малчдын өнөөгийн шатны нэг өвөрмөц онцлог бол тэдний ихэнх нь суурьшмал амьдралын давуу талыг сайн ойлгож сэтгэл зүйн хувьд суурьшихад бэлэн байна. Гэвч үндсэндээ жилийн турш байгалийн бэлчээр шүтсэн бэлчээрийн мал аж ахуйн материаллаг болон эдийн засгийн нөхцлөөс болж тэд нар бүрэн суурьших боломжгүй байна. Ийм учраас МАХН, Засгийн газар юуны өмнө малчдын нийгэм соёл, ахуй үйлчилгээг сайжруулах замаар ахмад үеийн болон залуу малчдыг тогтворжуулж малчдын материаллаг болон эдийн засгийн нөхцөл бүрдэх тусам тэднээс олон цөөнөөрөө хагас суурьшил буюу хагас нүүдлийн байдалд шилжих явдлыг урамшуулах арга хэмжээ авч байна. Хөрөнгөтөн орны зарим монгол судлаачид бичихдээ монгол орны удирдагчид бүх малчдаа суурьшуулж, бүх гэрээ устгах бодлого явуулж байна гэх мэтчилэн бичсэн боловч хэрэг дээрээ тийм биш юм.

Монгол гэр нь хүн амын ихэнх, ялангуяа нүүдэл болон хагас нүүдлээр амьдран буй малчдын орон сууцны нэгэн үндсэн хэлбэр болсоор ирсэн, цаашид ч болох болно.

Монгол орны нүүдэлчин болон суурьшмал амьдралын харьцааны өнөө үеийн нэг үндсэн шинж гэвэл дийлэнх хүн ам нь суурьшмал амьдралд шилжсэн боловч, нүүдэлч амьдралын нэг хэв шинж болсон гэрт суусаар байна. Энэ бол түүхэн сонирхолтой үзэгдэл бөгөөд нэг талаас суурьшмал амьдралд саяхан шилжин орсон. Нөгөө талаас хүн амыг орчин үеийн тохилог орон сууцаар хангах асуудал хурцаар тавигдаж байгааг харуулж байна. Ийм учраас МАХН, Засгийн газар ЗХУ-ын тусламжтайгаар хот, хөдөөд орон сууцны барилга байгуулах зорилгоор барилгын үйлдвэрийн баазыг нэмэгдүүлэн бэхжүүлэх талаар эрчимтэй арга хэмжээ авсаар байна. Үүний зэрэгцээ 1986—1990 онд гэрийн модон хэрэглэл мебель, гэр ахуйн бусад бараа, багаж үйлдвэрлэх хэмжээг 25%-иас доошгүй хувиар нэмэгдүүлэхээр төлөвлөсөн байна.

Өнөө үед Монголын ард түмний уламжлалт соёл, баялаг өвийг залгамжлагчид нь хөдөөгийн хүн ам, түүний дотроос нүүдэлч, хагас нүүдэлч амьдрал бүхий малчид л болж байна.

Бидний үзэж байгаагаар орчин үеийн, үүний дотор юуны өмнө европын соёл Монголын уламжлалт соёлын хөгжилд ихээхэн нөлөөлж байгаа боловч түүнийг дарж зонхилж чадахгүй байна. Харин ч Монголын орчин үеийн бүтээлч сэхээтнүүд орчин үеийн шинжлэх ухаан, техникийн ололтын үндсэн дээр өөрийн үндэсний соёлыг хөгжүүлэх дэвшилттэй хандлагыг баримтлах байдал үзэгдэх боллоо.

Ингэхээр 1921 оны ардын хувьсгалын дараа Монголын ард түмний уламжлалт амьдралд томоохон өөрчлөлт гарсан, одоо ч гарсаар байна гэж дүгнэж хэлж болно. Тус орны хүн амын дийлэнхи хэсэг нь орчин үеийн хэлбэр бүхий суурьшмал амьдралд бүрэн төгс шилжсэн байна. Тус оронд нүүдэлч болон суурьшмал амьдралд бүрэн төгс шилжсэн байна. Тус оронд нүүдэлч болон суурьшмал амьдралын хоёр ёс зэрэгцэн оршиж харилцан нөлөөлөх өвөрмөц процесс үргэлжилсээр байгаа нь нарийн өвөрмөц, зарим талаар зөрчилтэй боловч эсрэг тэсрэг биш шинж чанартай юм.

МАХН, засгаас уламжлалт амьдралын ёсны хэв маягийг аль болох түргэн бүрэн арилгах зорилт тавиагүй, харин ч тус оронд Монголын ард

түмний уламжлалт дэвшилтэт өв уламжлалыг амьдралын бүхий л салбарт хадгалах, үндэсний уламжлалт соёлыг орчин үеийн нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн дэвшлийн элементтэй зөв хослуулах бодлого баримталж байна.

Тус оронд үйлдвэржих, хотжих, суурьших, мөн улс хоорондын хамтын ажиллагаа хэдий эрчимтэй хөгжиж байгаа боловч монголчуудын үндэснийхээ өвөрмөц шинж чанар, соёлоо гээж байна гэж үзэх үндэсгүй.

ШИНЖЛЭХ УХААН,
СОЁЛ

**ШАГЖИЙН «ЧАНДМАНИЙН
ЭРХ»**

А. ЛУВСАНДЭНДЭВ
ШУА-ийн сурвалжлагч гишүүн

1929 онд тэр үеийн Шинжлэх ухааны хүрээлэнгийн ажилтан, толь бичгийн ухааны гарамгай эрдэмтэн Шагж гэлэн «Эрэхүйеэ хялбар болгон зохиосон монгол үгний тайлбар чандманий эрх» гэсэн гарчигтай монгол хэлний тайлбар толийг зохиож дуурсгасан нь эдүүгээ Улаанбаатар хотын Улсын нийтийн номын сангийн бичмэл номын хөмрөгт хадгалагдаж байна. Уул толийг орос цаасан дээр бичгийн машинаар маш нямбай цохижээ. Цаасны хэмжээ 23,5 x 20 см, бүгд 4 дэвтэр, оршил 2 тал хуудас, дугааргүй, жинхэнэ эх нь 1628 тал хуудас, хар бэхээр бийрээр монгол тоогоор хуудсыг дугаарласан, тал хуудас нь дугааргүй байна. Шар өнгийн даавуу хавтастай, хавтасны нүүр дээр «Монгол үгний тайлбар бичиг. Нэгдүгээр дэвтэр» гэх мэтчилэн гарчиглажээ. Шифр 494. 21. III 156, I, II, III, IV, дугаар 15760, 15761, 15762, 15763.

«Эрэхүйеэ хялбар болгон зохиосон» гэсэн гарчигтаа зохиогч бүтээлийнхээ зорилго, зарчмыг товчхон боловч тодорхой тунхагласан байна. Бидний гар дээр байгаа хэрэглэгдэхүүн мэдээ сэлтээс үзэхэд урьдын эрдэмтдийн зохиосон монгол хэлний тайлбар толиуд цөм зүйл хуваасан толь байлаа. Зүйл хуваасан толиноос хэрэгтэй үгээ олж үзэх гэдэг тийм хялбар биш, үлэмжхэн цаг гарзаддаг нь хэн бүхний мэдээжийн хэрэг билээ. Шагж гэлэн шал өөр зарчим дээр үндэслэсэн өөрөөр хэлбэл уйгаржин монгол үсгийн дэс дараа дээр үндэслэсэн толь зохиож, өмнө дурдсан дутагдлаас уншигч олон түмнийг ангижруулахаар шийджээ. Түүний бичсэн оршилд «Энэ бичгийг зохиосны санаа зорилгыг товчилбоос, ард олныг хэл бичигтээ амархнаар боловсорч, элдвээр бичих сонжигдох элэгдэхээс гэтлэн, үг өгүүллээр гачигдан мухардахуйн зовлонгоос даруй ангижиртугай хэмээсэн нь буюу» гэж бичсэн байна.¹

Иш татсан зүйлээс үзвэл, зохиогчийн зорилго тайлбар толийг ашиглахад хялбар болгох төдийгөөр хязгаарлагдсангүй, уншигч олныг монгол утга зохиолын хэлний үгсийн сангийн баялгийг зөв эзэмшүүлэх, зөв бичүүлж сургахыг нэгэн адил эрмэлзжээ. Мөнхүү оршилд Шагж гэлэн «манай улсын эрт цагт орчуулсан, зохиосон судар шаштирыг шинжилбээс мөнхүү дүрэм хэмжээ агсан нь илэрхий атал, хожмын үед бичгийг ёсчлон сурахуйд маш бэрхтэй болж их төлөв нь балрагдан, нялхасын